

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Налайх дүүргийн цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/15/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн захирал: Д.Товуудорж Утас: 9904-9511 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com Аудитын менежер: А.Гэрэлмаа Утас: 9949-9667 Цахим хаяг: gerelmaa_69@yahoo.com Аудитор: Д.Туяа Утас: 8811-4488 Цахим хаяг: tuya88999@gmail.com Аудитор: Н. Пүрэвсүрэн Утас: 9901-7013 Цахим хаяг: medeeleaudit@gmail.com</p>
-----------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15

№

530

танай _____-ны № _____-т

НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН АЛБА
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.
УРАНЧИМЭГ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Налайх дүүргийн цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Налайх дүүргийн цэцэрлэгжүүлэлтийн алба ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2023 оны 04 сарын 24-ны А/30 дугаар тушаалаар тус байгууллагын эргэлтийн бус хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэлтэй 485,700.0 мянган төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тартам замыг балансаас баланст шилжүүлэх шийдвэр гаргасан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 1 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ төлөвлөснөөс 22 арга хэмжээ нь 100 хувь, 1 арга хэмжээ 94.9 хувь, 1 арга хэмжээ 75.0 хувь биелж нийт 94.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2023 оны 01-р сарын 01	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	141,892,325.94	16,034,635.68
1.1.2	Дансны авлага	-	0.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	-	2,056,984.00
1.1.6	Бараа материал	889,781,719.00	523,218,866.30
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,031,674,044.94	541,310,485.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	839,147,517.87	874,794,653.98
1.2.2	Биет бус хөрөнгө	33,612.72	0.01
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	839,181,130.58	874,794,653.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,870,855,175.52	1,416,105,139.97
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1.1	Дансны өглөг	-	2,056,984.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.00	2,056,984.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.00	2,056,984.00
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	294,020,810.00	294,020,810.00
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- Хувьцаат	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	60,971,417.32	60,971,417.32
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,187,936,674.95	1,187,936,674.95
2.3.9	Хуримтлагдсан ашиг	327,926,273.25	(128,880,746.30)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,870,855,175.52	1,414,048,155.97
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,870,855,175.52	1,416,105,139.97

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	623,230,500.00	589,700,000.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	623,230,500.00	589,700,000.00
8	Бусад орлого	71,238,680.00	317,404,868.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	655,327,479.82	838,242,078.27
10	Ерөнхий ба удирдлагын зардал	22,928,538.83	30,344,828.28
11	Санхүүгийн зардал	68,900.00	24,600.00
12	Бусад зардал	12,025,658.00	9,600,281.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(485,700,100.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,118,603.35	(456,807,019.55)
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,118,603.35	(456,807,019.55)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	4,118,603.35	(456,807,019.55)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	171,726,328.59	(456,807,019.55)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	294,020,810.00	60,971,417.32	1,187,936,674.95	327,926,273.25	1,870,855,175.52
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	294,020,810.00	60,971,417.32	1,187,936,674.95	327,926,273.25	1,870,855,175.52
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(456,807,019.55)	(456,807,019.55)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	294,020,810.00	60,971,417.32	1,187,936,674.95	(128,880,746.30)	1,414,048,155.97

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	726,985,282.00	753,484,547.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтын орлого	623,230,500.00	589,700,000.00
	Бусад мөнгөн орлого	103,754,782.00	163,784,547.00
1.2	Мөнгөн зарлага (-)	314,987,470.46	879,342,237.26
	Ажиллагчдад төлсөн	264,342,112.83	366,865,426.07
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	73,383,946.00	106,281,674.24
	Бараа материал худалдан авахад төлсөн	137,914,120.00	254,978,106.83
	Ашиглалтын зардалд төлсөн	46,498,757.00	39,622,305.25
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	43,240,000.00	33,600,000.00
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	23,199,988.36	33,696,129.97
	Даатгалын төлбөрт төлсөн	-	-
	Бусад мөнгөн зарлага	28,402,989.00	44,298,594.90
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	110,003,368.81	(125,857,690.26)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,263,700.00	-
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,263,700.00	-
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,263,700.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	86,739,668.81	(125,857,690.26)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	55,152,657.13	141,892,325.94
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	141,892,325.94	16,034,635.68

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мян.төгрөг/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	694,469,180.00	632,700,000.00	907,104,868.00	74,451,292.00	143%
1.1	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	623,230,500.00	589,700,000.00	589,700,000.00	-	100%
1.2	Үйл ажиллагааны орлого	22,238,680.00	13,000,000.00	50,761,900.00	37,761,900.00	390%
1.3	НЗАА-наас гэрээт ажлын орлого	49,000,000.00	30,000,000.00	66,689,392.00	36,689,392.00	222%
1.4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	0.00	199,953,576.00	199,953,576.00	
2	Нийт зардал	690,350,549.65	629,478,000.00	1,363,911,887.55	734,433,887.55	217%
2.1	Цалингийн зардал	300,524,680.83	413,400,000.00	437,007,165.28	23,607,165.28	106%
2.2.1	Нийгмийн даатгалын шимтгэл	39,180,128.00	55,809,000.00	56,906,591.00	1,097,591.00	102%
2.2.2	Албан татвар төлбөр хураамжийн зардал	307,166.66	450,300.00	520,900.00	70,600.00	116%
2.2.3	Ашиглалтын зардал	32,745,119.00	18,000,000.00	20,756,205.00	2,756,205.00	115%
2.2.4	Засвар үйлчилгээний зардал	4,862,900.00	9,000,000.00	15,896,000.00	6,896,000.00	177%
2.2.5	Үйл ажиллагааны зардал	117,051,868.00	47,985,800.00	153,225,623.70	105,239,823.70	319%
2.2.6	Хог хаягдлын зардал	720,000.00			-	
2.2.7	Шуудан харилцаа холбооны зардал		1,020,000.00	940,206.00	(79,794.00)	92%
2.2.8	Аудит баталгаажуулалт	7,600,000.00	-	3,800,000.00	3,800,000.00	
2.2.9	Тээвэр, шатахуун зардал, шатах тослох материал	49,860,800.00	48,938,400.00	34,666,738.90	(14,271,661.10)	71%
2.2.10	Бичиг хэрэг	4,740,110.00	5,957,500.00	4,538,250.00	(1,419,250.00)	76%
2.2.11	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	2,995,330.00	2,004,000.00	1,601,270.00	(402,730.00)	80%
2.2.12	Хөдөлмөр хамгаалал, ГББ-ын зардал	10,080,350.00	4,913,000.00	3,152,290.00	(1,760,710.00)	64%
2.2.13	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,469,772.00	4,000,000.00	1,283,900.00	(2,716,100.00)	32%
2.2.14	Элэгдэл зардал	117,212,325.16	-	118,045,701.59	118,045,701.59	
2.2.16	Байрны түрээс граж		18,000,000.00	20,100,000.00	2,100,000.00	112%
2.2.17	Бусад зардал			5,770,946.08	5,770,946.08	
2.2.18	ҮХ данснаас хассан гарз			485,700,100.00	485,700,100.00	
3	Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал	4,118,630.35	3,222,000.00	(456,807,019.55)	(460,029,019.55)	
4	Орлогын татвар				-	
5	Цэвэр ашиг, алдагдал	4,118,630.35	3,222,000.00	(456,807,019.55)	(460,029,019.55)	
6	Орлогын нэг төгрөгт ноогдох зардал					

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 1,821.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,821.7 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зарлагын гүйлгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй	1	1,513.2					1	1,513.2				
Цалингийн дэлгэрэнгүй бүртгэл нийгмийн даатгалын тайлангийн нийт цалингийн дүн зөрүүтэй	1	200.0					1	200.0				
Шатахууны зарцуулалт санхүүгийн тайлан дахь шатахууны тодруулгын дүнгээс зөрүүтэй	1	108.52					1	108.52				
Дүн	3	1,821.72					3	1,821.72				

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аудитаар нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1						1	
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ОНА	1	1			1			
Нийт		1	1			1			

